



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/251


Булган

Ажлын хэсэг томилох тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, “Төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах”, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнгийн байдалд батлагдсан удирдамжийн дагуу улсын үзлэг зохион байгуулан санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардлагатай хөрөнгийн задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэгийг 2019 оны 05 дугаар сарын 06-аас 05 дугаар сарын 25-ны өдөр хүртлэх хугацаанд зохион байгуулж, тайланг нэгтгэж, цаашид сангийн үйл ажиллагааг сайжруулах талаарх санал дүгнэлтийн хамт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг ажлын хэсэг /О.Наранжаргал/-т үүрэг болгосугай.
3. Улсын үзлэг зохион байгуулахад шаардагдах шатахууны зардал 804460 /найман зуун дөрвөн мянга дөрвөн зуун жар/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Б.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 07
өдрийн..... тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

**“СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: О.Наранжаргал /АЗДТГ-ын дарга/

Гишүүд: Ч.Амгалан /ХХААГ-ын дарга/

О.Сайнзаяа /СТСХ-ийн мэргэжилтэн/

Б.Очирсүрэн /СТСХ-ийн мэргэжилтэн/

Ч.Оюун-Эрдэнэчимэг /ХОХБТХ-ийн мэргэжилтэн/

Ж.Оюунгэрэл /ХЭЗХ-ийн мэргэжилтэн/

Н.Дэлгэрнамжил /ХЭЗХ-ийн мэргэжилтэн/

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн

Сумын ЗДТГ-ын “Сум хөгжүүлэх сан” хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Б.Батбаяр /ХХААГ-ын Жижиг, дунд үйлдвэр хариуцсан
мэргэжилтэн/

1.Сайхан, Баян-Агт, Тэшиг, Хутаг-Өндөр сумдад ажиллах ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч: О.Наранжаргал /АЗДТГ-ын дарга/

Гишүүд: Ч.Оюун-Эрдэнэчимэг /ХОХБТХ-ийн мэргэжилтэн/

О.Сайнзаяа /СТСХ-ийн мэргэжилтэн/

Н.Дэлгэрнамжил /ХЭЗХ-ийн мэргэжилтэн/

Сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн

Сумын ЗДТГ-ын “Сум хөгжүүлэх сан” хариуцсан мэргэжилтэн

2. Бүрэгхангай, Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-
Өндөр, Орхон, Булган, Бугат, Сэлэнгэ, Хангал сумдад ажиллах ажлын хэсэг:

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Амгалан /ХХААГ-ын дарга/

Гишүүд: Б.Батбаяр /ХХААГ-ын Жижиг, дунд үйлдвэр хариуцсан

мэргэжилтэн/

Б.Очирсүрэн /СТСХ-ийн мэргэжилтэн/

Ж.Оюунгэрэл /ХЭЗХ-ийн мэргэжилтэн/

Сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн

Сумын ЗДТГ-ын “Сум хөгжүүлэх сан” хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2019 оны сарын
 өдрийн тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

**“СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
 ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

Хүснэгт-1

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг	Нийт үнэ /төг
1	Тээвэр шатахуун	л	413	1850	764460
2	Масло	л	4	10000	40000
	Нийт				804460

Хүснэгт-2

Шатахууны тооцоо

№	Гарах сумд	Очих сумд	Сум хоорондын км	Зарцуулах бензин / норм 100км-20л пургон автомашин /	Нэгжийн үнэ	Бүгд /төгрөг/
1	Булган	Бугат	70	14	1860	26040
2	Бугат	Хангал	112	22.4	1860	41664
3	Хангал	Хялганат	60	12	1860	22320
4	Хялганат	Сэлэнгэ	80	16	1860	29760
5	Сэлэнгэ	Булган	140	28	1860	52080
6	Булган	Тэшиг	255	51	1860	94860
7	Тэшиг	Хутаг-Өндөр	133	26.6	1860	49476
8	Хутаг-Өндөр	Баян-Агт	180	36	1860	66960
9	Баян-Агт	Сайхан	110	22	1860	40920
10	Сайхан	Булган	110	22	1860	40920
11	Булган	Дотор	90	18	1860	33480
12	Булган	Орхон	25	5	1860	9300
13	Орхон	Бүрэгхангай	70	14	1860	26040
14	Бүрэгхангай	Дашинчилэн	90	18	1860	33480
15	Дашинчилэн	Баяннуур	50	10	1860	18600
16	Баяннуур	Рашаант	140	28	1860	52080
17	Рашаант	Гурванбулаг	90	18	1860	33480
18	Гурванбулаг	Могод	100	20	1860	37200
19	Могод	Хишиг-Өндөр	80	16	1860	29760
20	Хишиг-Өндөр	Булган	70	14	1860	26040
Нийт шатахуун			2055	411		764460
Масло				4	10000	40000
						804460